

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 7-24

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	7-9
2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-24

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 23-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 39 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Т.Доржханд;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгэрэл,
Л.Энх-Амгалан.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 42 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсын Засгийн газраас 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын

төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Э.Одбаяр, Ж.Баярмаа, Ө.Шижир нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 05 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 39 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны ирц бүрдсэн тул гишүүдээ урьж байна. Гишүүд хүрэлцэн ирэхийг урьж байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд, энд алга байна шүү дээ, хүрэлцэн гишүүдийг танилцуулъя. Энэ чинь яачихсан байсан юм. Уянгахишиг гишүүн ирсэн байна, Алтангэрэл, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн тул, ирц 60 хувь болсон байна. Ингээд ирц бүрдсэн тул Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалт, Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2025 оны 6 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. 2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 9 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 8 гишүүнээс 18 гишүүн оролцож, 53,3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүнээс 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 8-аас 18 гишүүн оролцож, 53,3 хувиар санал дэмжигдлээ. 15-аас 8 гишүүн дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найрлага/ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би санал хураалтад оролцож амжсангүй. Горимын санал гаргая. Дахин санал, саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал гаргаж байна. Санал хураалт явуулъя. Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн оролцож, 60 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүнээс 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн оролцож, 60 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн оролцож, 60 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 42 гишүүнээс 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн “Төрөөс төмөр замын талаар баримтлах

бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 12 гишүүн оролцож, 80 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа нарын 9 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүнээс, 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

14.49 цаг

Хоёр.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дугаар асуудалдаа оръё. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх тухай, 33.2.нэгдсэн хуралдаан хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын нийт гишүүнд яаралтай хүргүүлж, энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцүүлнэ гэсэн байгаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Жавхлан сайд хүрэлцэн ирсэн байна. Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар сайд хүрэлцэн ирсэн байна. Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулна. Хэн? Бямбацогт сайд танилцуулах уу? Бямбацогт сайд танилцуулна, Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт сайд танилцуулна. Ажлын хэсгийг дуудсан уу? Ажлын хэсгийг танилцуулъя. Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, С.Бямбацогт Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Б.Жавхлан Сангийн сайд, Д.Мөнх-Эрдэнэ ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Д.Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Б.Төрбат ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын референт, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга, 3.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга. Бямбацогт. Занданшатар Ерөнхий сайдын микрофоныг нээе.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан. Энэ хуульд заасны дагуу Бүрэлдэхүүний тухай хуулийг нэн яаралтай горимоор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын ЗГ нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэж, хүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог багасгах, инновац, шинэ технологи, хиймэл оюун ухаанд суурилсан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж, шат дамжлагыг бууруулах, үйл ажиллагаандаа ил тод хяналт тавих байдлыг сайжруулах, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зэрэг зорилт арга хэмжээг ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган Улсын Их Хурлын 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлуулсан.

Өнөөдөр ард иргэдэд гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалсан үнийн өсөлтийн эрсдэл улам бүр дарамт учруулж байна. Өнөөдөр ард иргэдэд цалин, тэтгэвэр, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, орон сууцжуулах зэрэг олон асуудлууд тулгамдаж байна. Сүүлийн үеийн олон нийтийн судалгаагаар 10 иргэн тутмын 4 нь амьдрал муудсан нь, 5 нь өөрчлөгдөөгүй гэж хариулсан. Иймд манай ЗГ энэ судалгаанд үндэслэн бодлогыг хэрэгжүүлж, ард иргэдийнхээ өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг зөв эрэмбэлж, амьдрах орчин нөхцөлийг иргэддээ ээлтэй болгохын тулд гадаад тарифын дайн, гадаад геополитикийн зөрчилдөөнөөс шалтгаалан түүхий эдийн үнэ унаж, төсөвт ихээхэн хэмжээний дарамт учруулж байгаа энэ нөхцөл байдлуудыг харгалзан үзэж төсвийн тодотгол хийхээр зорьж байна. Олон улсын харилцаа, геополитикийн хурцадмал нөхцөл байдал хэвээр үргэлжилж байгаа энэ цаг үед худалдааны тарифын зөрчилдөөн, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн уналтаас үүдэлтэй эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг улс орны хөгжлийн өмнө тулгамдсан томоохон сорилт бэрхшээлийг харилцан ойлголцолд тулгуурлан, зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Ийм учраас ЗГ-ын тогтвортой байдлыг хангаж, залгамж чанарыг хангахын тулд өмнөх ЗГ-ын мөрийн хөтөлбөрийг өөрчлөхгүй үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Улсын Их Хурлаар батлагдсан ЗГ-ын үйл ажиллагааны 2024-өөс 2028 оны мөрийн хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай. Сонгогчдын саналыг гээхгүй, сонгогч бүрийн саналыг тусгасан олон намуудын мөрийн хөтөлбөрөөс авсан шигшиж, нийлүүлж хийсэн энэ мөрийн хөтөлбөрийг үргэлжлүүлж ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Ийм учраас энэ ЗГ-ын тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмыг үндэслэн ЗГ-ын бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зорилгоор ЗГ-ын бүтцийг зарчмын хувьд хэвээр үлдээж, бүрэлдэхүүний хувьд Ерөнхий сайд ЗГ-ын 19 гишүүнтэй ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр баталсан ЗГ-ын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах буюу тус хуулийн 1 дүгээр зүйлд заасан ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний үндэсний хорооны дарга, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргатай холбоотой хэсгийг тус тус хүчингүй болгохоор тус тус тусгалаа. Ийнхүү яамдыг цөөлж, сольж нийлүүлж, тогтворгүй байдлыг үүсгэж, бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг алдагдуулснаас илүү эдгээр чиг үүргүүдийг бусад яамдад зохистойгоор хуваарилж, төрийн бүтцийг цомхон, зохистой, уялдаа холбоотой, хариуцлагатай болгохыг зорьж байна. Энэ бол зөвхөн хэмнэх алхам биш, харин бодлого, хэрэгжилт, хариуцлагын л, хариуцлагын гүйцэтгэлийг нэг цонхонд төвлөрүүлж, институт хоорондын давхардлыг арилгах стратегийн өөрчлөлт юм.

ЗГ-ын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан Үндэсний баялгийн сангийн асуудал, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэгдсэн бодлого, төрийн бүтээмж, нээлттэй засаглалын түншлэлийн асуудал, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад, хууль тогтоомж ЗГ-ын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын, хилийн бүс дэх тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хилийн боомтын болон стратегийн орд газрыг холбосон дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн асуудлыг Сангийн сайдын, хотын хэт төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй, шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх бодлого, зохицуулалт, авто замын түгжрэлийг бууруулах асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд тус тус хамааруулахаар заалаа.

Түүнчлэн дээрх өөрчлөлттэй холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт оруулахаар тусгалаа. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхий сайд ЗГ-ыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг хариуцна гэж заасны дагуу Ерөнхий сайдаар томилогдохдоо дэвшүүлсэн бодлого, зорилтоо хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Энэ өөрчлөлтөөр шинэ ЗГ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэхээс гадна давхардсан чиг үүргийг арилгах, бодлогын хэрэгжилт сайдын шууд хариуцлагад хамаарах, үр ашиггүй бүтэц зардлыг багасгах, төрийн хариуцлага, гүйцэтгэлийн хяналт сайжрах боломжтой болно гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах суурь нөхцөлүүдийг бүрдүүлэхийг зорьж байна. Үүнд ард иргэддээ ээлтэй, ойрхон байж үйлчилдэг төр байх. Монгол хүний хөгжил бол төрийн бодлогын цөмд байх, хөдөлмөр эрхлэлт, орлогын шинэ боломжийг сайжруулах, хот, хөдөө тэгш хөгжих үндэс бүсчилсэн хөгжлийг бодитой хэрэгжүүлэх, цомхон, чадварлаг, зохистой төрийг бий болгох, татварын реформыг хэрэгжүүлэх, Засгийн газар ил тод байж иргэдийн оролцоог хангах, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүх түвшинд хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн суурь бүтээн байгуулалт мега төслүүдийг эрэмбэлж хэрэгжүүлэх, энэ зорилтуудыг хэрэгжүүлэх ил тод засаглалыг бий болгох, олон нийтийн хяналтыг сайжруулахыг зорьж байна.

ЗГ-ын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан ЗГ-ын зарим гишүүний эрхлэх асуудлын нийцлийг хангах зорилгоор ЗГ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ЗГ-ын хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг эрхэм гишүүдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Одбаяр гишүүнээр тасаллаа. Одбаяр гишүүн.

Э.Одбаяр: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд асуулт гэхээсээ илүүтэйгээр санал байна. Тэгээд яах вэ боломж байвал хариулна биз. Бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль дээр уламжлал хэв шинжээ хадгалж гэдэг үгийг сая Ерөнхий сайд хэлж байх шиг байна. Өмнөх ЗГ-ын үед кабинетыг бүрдүүлж байсан сөрөг хүчний төлөөлөл 2 дахь олон суудалтай намын дарга нь Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд гэдэг албыг хашдаг байсан. Тэгэхээр одоо Монгол Ардын намаас энэ ЗГ-т ажиллаж байгаа 3 Шадар сайдын 2 нь ажиллаж байгаа. Тэгэхээр яг энэ үнэхээр энэ өмнөх уламжлал шинэчлэлээ хадгалж энэ бүтцээ хийсэн гэдэгтэй энэ оруулж ирсэн санал чинь нийцэж байгаа эсэх дээр Ерөнхий сайд байр сууриа илэрхийлэх нь зөв байх.

2-т Сангийн сайд мэдэж байгаа байх Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн дагуу төрийн албаны төрийн өмчит ААН-ийн, төрийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй 2 жилийн өмнө шинээр байгуулагдсан ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрыг анх танай нам үнэмлэхүй олонх байхдаа хуулийг нь баталж байгуулж байсан. Одоо тэгээд тэр газраа хүнийг нь дагуулаад нөгөө төлөвлөлт хийж байгаа Эдийн засаг, хөгжлийн яам руугаа аваачиж өгч байгаа нь төлөвлөлт, төсөвлөлт, хяналт 3 нь нэг платформ дээр, 3 өөр үл хамаарах субъект дээр ажил нь хариуцаж байж үр дүнтэй байна гэдэг энэ бодлого концепц дээрээ хэр нийцэх вэ гэдэг дээр хариулт өгөх хэрэгтэй байх.

Ер нь адилхан төрийн захиргааны статустай байгууллага, яамнуудтайгаа адилхан төрийн албан хаагчид нь тэнд ажиллаж байгаа албан хаагчид нь яамд, яамнуудтайгаа адилхан статустай болчихоод бусад яамдаа хянаана гэдэг нь учир дутагдалтай байдаг. Тэгээд өнөөдрийг хүртэл явж ирсэн энэ уламжлалыг нь эвдээд, өөр газар харьяалуулж байгаа дээрээ зөв гэж үзэж байгаа юу, буруу гэж үзэж байгаа юу? Ер нь Байнгын хороон дарга энэ дээр зарчмын зөрүүтэй горимын санал гаргах боломж байгаа юу? Энэ дээр горимын санал гаргаад, хуучнаар нь буюу өмнө нь хуучин энэ ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар Хэрэг эрхлэх газрын харьяанд байсан тэнд нь буцаагаад шилжүүлье гэдэг дээр горимын санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ чинь анхны хэлэлцүүлэг биз дээ, хэлэлцэх эсэх шүү. Занданшатар дарга, Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: ЗГ-ын уламжлал, шинэчлэлийн бодлогыг хослон хэрэгжүүлнэ гэдэг нь ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн залгамж чанарыг уламжлалыг хадгална. Ер нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт төдийгүй, нийт иргэдэд хүндрэл учруулдаг зүйл бол нэг Засгийн газар өөрчлөгдөөд л яамнууд солигдоод л, бүх бодлого нь өөрчлөгдөөд л, нэг цахилгаан станц барих гэж байснаа түүнийг болиулаад л өөр цахилгаан станц бариад л явчихдаг ийм чирэгдэл бол ард иргэдэд хүнд дарамт учруулж байсан, хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлж байсан ийм жишиг энэ судалгаануудаар дүүрэн байна. Энийг бол уламжилж бодлогын уламжлал, залгамж чанарыг хадгална гэж байгаа юм. Түүнээс биш мөрийн хөтөлбөр хийх ажил нь тодорхой юм чинь ЗГ-ын Тэргүүн Шадар сайд, Шадар сайд нарын хэрэг эрхлэх асуудлууд илүү өргөжөөд, илүү тодорхой болохыг зорьж байгаа юм.

Засгийн газар дахь хяналтын асуудал ихээхэн чухал асуудал. Та хэрвээ уншсан бол наана чинь хууль, ЗГ-ын гаргасан шийдвэрийн хяналт бол Хэрэг эрхлэх газар дээр байж байгаа. Харин энэ эдийн засгийн бодлого, төлөвлөлт түүний хяналт хэрэгжилт цаашдаа энэ Мэргэжлийн хяналт, бүтээмжийн зөвлөл нэртэйгээр цаашдаа шинэчлэгдэж, энэ мэргэжлийн хяналттай байх нь зүйтэй гэдэг асуудал яригдаж байгаа. Энэ цаашдаа энэ дараа дараагийн намрын чуулганаар хэлэлцэх байх. Өнөөдөр үндсэндээ сумд эрүүл ахуйн чанар шаардлага хангадаг, хянадаг газар байхгүй болсон. Тэнд хугацаа нь дуусчихсан, хүүхэд, багачуудад эрүүл мэндийн шаардлага хангасан уу, хугацаа нь дууссан уу, хаанаас орж ирсэн нь тодорхойгүй бараа, бүтээгдэхүүн их хэмжээгээр зарагддаг болж, хяналт тавигдахаа болилоо гэсэн ийм яриа шүүмжлэл ЗГ-т их ирж байгаа, 11 11 төвд. Ингээд хяналт маань зүгээр зөвхөн засаглалын, дээр нь хувийн хэвшилд хүндрэл чирэгдэл учруулдаг боллоо. Яам болгоны хяналт шалгалт давхцаж ирдэг боллоо. Хуучин энэ бүхнийг нэгтгээд нэг Мэргэжлийн хяналт гээд нэг хяналт нэг л очих зорилготой байсан чинь одоо яам болгоны хяналт сар алгасалгүй хувийн хэвшил дээр янз бүрийн хяналт шалгалтууд ирж дарамт шахалт учруулж байна гэж ингэж ярьдаг ийм санал шүүмжлэлүүд ч гарсан.

Тийм учраас хяналтыг тодорхой болгох зорилгоор Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн. Хуучин угаасаа Шадар сайдын харьяанд Мэргэжлийн хяналт байсан тийм уламжлалтай байж ирж байсан. Харин ЗГ-ын хяналт үнэлгээ, мониторинг буюу ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийг Хэрэг эрхлэх газар дээр хяналт шинжилгээ, үнэлгээний газар байж хэрэгжүүлж, хянаж ирсэн. Ийм түүх, ийм зарчимтай, энэ зарчмыг хуучин зарчмаа үндсэндээ хадгалсан байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн нэмэх гэж байна уу? Учрал гишүүн тодруулъя. Одбаяр гишүүн асуултаа тодруулъя.

Э.Одбаяр: Ерөнхий сайдыг, Ерөнхий сайдыг концепцоо ойлгоогүй байгаад нь их харамсалтай байна. Мэргэжлийн хяналтын байгууллага байх, үл байхаас үл хамаараад салбарын хяналтын асуудлаас илүү энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар буюу энэ Засгийн газар дахь хяналтын тухай хууль бол төрийн албан хаагчид, төрийн өмчит ААН, төрийн захиргааны байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж, дотоод хяналт гэдэг чинь гадагшаа гардаг, салбарын хяналт буюу хувийн хэвшил, иргэд, ААН рүү гарч байгаа гадаад хяналтаас тусдаа асуудал. Тэгээд энэ 2 өөр асуудлаа хольж яриад байж байгаад нэг харамсалтай

байна. Тэгээд ер нь өнгөрсөн хугацаанд хамтарсан Засгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, кабинет дотроо дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргээр байгуулагдсан энэ ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар энийгээ та хэд маань ингээд өөх ч биш, булчирхай ч биш болгож байгаад харамсаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал Шадар сайд энэ асуудалтай холбогдуулж дэлгэрэнгүй хариулна. Ер нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийг Улсын Их Хурлаар баталсан юм. Мөн хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний баримт бичгийн хяналтад хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлагналын асуудал нь бодлого төлөвлөлтийн нэг үе шат байна, цогц байх шаардлагатай гээд заачихсан юм. Одбаяр сайдаа ойлгож байна уу? Эдийн засгийн яам бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлж байгаа бол тэрнийхээ хэрэгжилтийг өөрөө хянадаг байна гэсэн, цогц байна гээд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заачихсан юм. Энэ бидний энэ баталсан хуулийн зарчим зарим талаас алдагдаад байна гэж үзэж байгаа юм. Төлөвлөлт, хэрэгжилтийн зохион байгуулалт болон хяналт үнэлгээ, тайлагналтыг нэгдсэн цогц бодлого, удирдлага, зохион байгуулалттайгаар хангах чиг үүргийг Монгол Улсын Шадар сайдад шилжүүлж байгаа ийм учиртай. Энэ талаар Учрал сайд дэлгэрүүлж хариулна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай холбоотой түүнд яаж хяналт тавьдаг нь энэ хууль дээр ажилласан манай Сандагийн Бямбацогт сайд илүү тодорхой зааж өгч, хэрэгжүүлэх байх.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн, Шадар сайд.

Н.Учрал: Тийм. ирэх оны төсвийн төсөөлөл, энэ төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яаманд харьяалагддаг. Ингээд өнгөрсөн бүтэн жилийн хугацаанд улсын жилийн төлөвлөгөө, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр боловсруулагдсан. Эндээс жишээ нь юуг буруу төлөвлөсөн юм, төсвийн мөнгийг үр ашиггүй юунд зарцуулсан, эдийн засагт үүсэж байгаа хор нөлөөг хэрхэн тооцсон, ирэх онд тэр бодлого, төлөвлөгөөнийхөө юунд анхаарах ёстой вэ гэдэг хөгжлийн бодлогын баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ өөрөө үнэлгээ хийдэг буюу төсөвлөлт, төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ гэдэг чинь ийм цикл. Ингэж явахгүй болохоор өмнө нь бид нөгөө Байнгын хороон дээр орж ирэхээр 3 сайд орж ирээд хэн нь нөгөө бодлого, ЗГ-ын хөтөлбөрөө хамгаалах юм бэ гэдэг нь ойлгомжгүй байсан. ЗГХЭГ бол нөгөө хууль тогтоомжийн хэрэгжилт буюу дотоод тэр асуудлаа хариуцаад явна. Эдийн засгийн яам бол хөгжлийн бодлого.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Учрал Шадар сайд дахиад минут нэмье.

Н.Учрал: Тэгэхээр тэр 4 жилийн үйл ажиллагааныхаа хөтөлбөр дээр суурилсан жилийн төлөвлөгөөгөө өөрөө үнэлээд, Их Хурал дээр ч гэсэн хамгаалаад гардаг байхгүй бол Их Хурлаар баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр тэр аймаг, орон нутагтай хэрхэн уялдаж байгаа юм, тэр салбаруудын ажил хэрхэн урагшилж байгаа юм, яагаад тэр 5 сарын 31-нээс өмнө үйл ажиллагааны хөтөлбөрт тусгачихсан ажлуудаа тендер юмыг нь зарлаж эхлүүлж чаддаггүй юм. Одоо 5 сарын 31 гэхэд 500 гаруй төсөл, хөтөлбөр зарлагдахгүй болоод ингээд татагдаж байна гэдэг чинь төлөвлөлт өөрөө эргээд

үнэлгээгээ хийж чадаагүйтэй л холбоотой. Тэгэхээр Хөгжлийн яам, Хөгжлийн яам гэдэг бол Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хуулиа барьж ажиллана. Боловсруулсан өөрийнхөө бодлогоо өөрөө мониторинг хийнэ. Ингээд нөгөө Одбаяр сайд бидний ярьдаг тэр дизайн буюу загвараа гаргаад, мониторинг хийгээд, тэр эволюшн хийдэг. Энэ бол ингээд бүтэн циклээр эргэнэ. Тэгээд ЗГ-ын хууль тогтоомж, тогтоол шийдвэр дээр мэдээж Хэрэг эрхлэхийн газар ингээд хариуцаад явна гэж ингэж л салгаж явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар чинь Монгол Улсын яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний ажилтнууд, мөн агентлагууд, түүний ажилтнууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН-үүд, түүний дарга, цэрэг, дарга нар энэ бүх зүйлийг чинь ерөөсөө дарга нарыг л хянадаг байгууллага байхгүй юу. Тэр дарга нарыг хянах замаар энэ төрийн үйл ажиллагаанд шударга ёсыг бэхжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх энэ бүх ажлуудыг хийсний үр дүнд ЗГ-ын үйл ажиллагаа сайжирна гэсэн ийм л зорилгын дагуу энэ газар байгуулагдсан. Тэгэхээр Ерөнхий сайд болон таны ярьж байгаа зүйл бол тэр нөгөө нэг ард иргэдийн, ААН-үүдийн ясыг нь янгинуулдаг байсан мэргэжлийн хяналтыг байгуулах тухай асуудал яриад байна л даа. Тэгээд энэ нь буцаад байгуулагдаж байгаа юм байна.

Тэгэхээр танд нэг зүйлийг ингээд хэлэхэд хүнд зориулж яам байгуулдаг, хороо байгуулдаг, хороо хариуцсан сайд бий болгодог, тэгээд хүнд зориулж тэр дотор ЗГ-ын бүтцийг нааш, цааш нь болгодог ийм зүйл байгаад байгаа. 2024 оны 7 сарын 9-ний 1 цагийн үед Хөгжлийн бүсчилсэн хөгжлийн хороо гэдэг зүйлийг уул нь Амарсайхан сайд өөрөө би саналаа татлаа гэж хэлээд хулгайлсан, хуулийн хулгай хийсэн байхгүй юу даа. Тэгэхээр тэр бүсчилсэн хөгжлийн хороо бол яг таны дор байх ёстой байхгүй юу Учрал сайдаа. Бүсчилсэн хөгжлийн хороо чинь. Энийгээ тийшээ Үндэсний хороо, тэрнийгээ ав л даа. Тэрний оронд тэгээд л тэр Засгийн газар дээрээ анхнаасаа Засгийн газар хоорондын яамд хоорондын уялдааг хангадаг, хяналт шалгалтыг хийдэг тэр газрыг ийшээ ингээд өөртөө зориулж авна гэж тэр бүх бугийг чи өөртөө авч яадаг байна вэ? Тэгээд тийшээ шилжүүлнэ гэдэг чинь нэг газар болгож авч байгаад л бүгдийг нь нөгөө нэг Ардчилсан намынхнаа танай намын бага хурал дээр хэлэгдсэн Ардчилсан намынхан бүх хяналт шалгалтыг авч байгаад бүгдийг нь будаа болголоо, одоо бид бүр баларлаа гэж та нар ярьсан байна лээ шүү дээ. Тэгээд тэр хүмүүсийг бүгдийг нь халж хаях юм байна л даа.

Бямбацогтын доор байсан ч хална л даа. Тэгэхдээ Бямбацогт энэ тэр бол орон нутагт байгаа тэр хулгай хийдэг АТГ-д шалгуулдаг тэр бүх хүмүүсээ хамгаална. Авлигал авсан хүмүүс нь, ногоон автобусны хэрэгт оролцсон хүмүүс энд орж ирчихсэн л сууж байна. 100 сая төгрөгийн авлигал авч байгаад 30-ийг нь яг гардан баригдсан нөхөр Дулааны цахилгаан станцын 3 дугаар цахилгаан станцын дарга хийж байгаа, одоо хүртэл шоронд явахгүй байж байгаад дэлбэлээд хаячихлаа шүү дээ. Та нар яагаад ингээд хулгайч нартайгаа тэмцдэггүй юм бэ? Энэ хулгайч нартай чинь тэмцэх гэж, тэр дарга нартай тэмцэх гэж энэ хяналт хэрэгжүүлэх газрыг чинь байгуулсан байхгүй юу даа. Тэгээд ингээд л хүнд зориулж шилжүүлдэг ийм байж ерөөсөө болохгүй. Энэ дээр би эсэргүүцэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэлчихлээ. Ерөнхий сайд Занданшатар хариулъя.

Г.Занданшатар: Энэ 1 дүгээрт мэргэжлийн хяналт сэргэж байгаа юм байхгүй. Ард иргэд тэгж шаардаж байгаа, асуудал үүсэж байгааг хэлсэн. 3 дугаар цахилгаан станцын даргыг ажил аваад эхний өдрөө бид онцгой дэглэм тогтоож, 3 дугаар цахилгаан станцын даргыг ажлаас чөлөөлж, энэ онцгой дэглэм тогтоож, бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Шоронд явуулахыг та бид 2 мэддэггүй юм. Хууль хяналтын байгууллага нь шалгаж тогтоож байгаа, шалгалтын ажил явж байгаа. Ер нь Байнгын хороог шүүх хурал болгож болохгүй. Мэдээж буруутай бол холбогдох газар шийдээд явна. Ажлаас нь чөлөөлсөн байгаа гэдгийг би танд мэдэгдэж өгөх гэсэн юм. Тийм. Бямбацогт дарга гүйцээгээд хариулчих.

Ж.Бат-Эрдэнэ: Бямбацогт ЗГХЭГ-ын дарга.

С.Бямбацогт: Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх ерөнхий газрын чиг үүрэг үндсэндээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу л салж байгаа юм. Хууль тогтоомжийн биелэлт, ЗГ-ын шийдвэрийн биелэлт, тогтоолын биелэлтийг хуучин ЗГХЭГ дээр хяналт тавьж, үр дүнг нь тооцож, хяналт шалгалтын үйл ажиллагаа явагддаг байсан. Одоо яг энэ рүүгээ салаад ЗГХЭГ-ын энэ чиг үүрэг нь ирж байгаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд заасны дагуу хөгжлийн бодлогын бичиг баримтууд, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн үндсэн төлөвлөгөө, Монгол Улсын төсвийн гүйцэтгэл гээд энэ олон Улсын Их Хурлаар баталдаг бодлогын бичиг баримтуудын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ хийх ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд анхнаасаа Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж хянана гэж заасан байсан. Үүний дагуу үндсэндээ Хяналт хэрэгжүүлэх ерөнхий газар луу энэ хөгжлийн бодлогын бичиг баримтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажил нь тийшээ шилжиж байгаа юм. Ингэж 2 хуваагдаж байгаа. Тэгээд үндсэн агентлаг бол Эдийн засгийн хөгжлийн яам.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн. Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Үгүй ээ, би танд баяр хүргэе. Тэр Дулааны цахилгаан станцын 3-ын нөхрийг очингуутаа сольсон байна. Тэгээд Тавинбэхээр өгөхөөр яадаг юм бэ, Тавинбэх чинь тэнд баахан юм шахдаг Архангайн нөхөр байхгүй юу. Архангайн нөхрөө тавьж байгаад шахаж байсан байхгүй юу. Тавинбэхийг нь тавьчихлаар бүүр завхарна, наадах Тавинбэхийг нь хурдан зайлуулахгүй бол тэнд бүх бараа, бүтээгдэхүүн шахдаг нөхөд чинь тэр Тавинбэх байхгүй юу. Нөгөө нэг нөгөө ямар ч нэмэр байхгүй, нөгөө нэмэгдэхүүний байрыг өөрчлөөд нийлбэр өөрчлөхгүй гэдэгтэй адилхан л болж байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд ЗГ-ын бүрэлдэхүүн зөвхөн орж ирж байгаад жоохон харамсаж байна. Уг нь бүтцэд өөрчлөлт хийж болохгүй байсан юм байх даа гэсэн асуудлыг өмнө нь ч гэсэн дурдаж байсан. Тэгээд тэр яг л хуучнаараа орж ирлээ л дээ. Тэгээд яах вэ Засгийг тогтвортой байлгах ёстой гэдэг нэг ийм шалтаг шалтгаан хэлээд байх юм. Гэтэл тогтвортой байх нь чухал юм уу, үр ашигтай, үр дүнтэй, ялангуяа энэ эдийн засгийн хүндрэлтэй үед чухал юм уу гэдгийг уг нь нэлээн тийм дэнслэх ёстой байсан санагдаад байна л даа. Тэгээд жишээлбэл реформ хийнэ гэдэг чинь ерөөсөө энэ Засагт бүтэц оруулах л гэж би бараг ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд тэрийг

дагасан тэр том бүтэц тэр аяараа хөдөлж байж энэ чинь дорвитой өөрчлөлт төрийн албанд орох болов уу гэж уг нь бодоод байгаа юм.

Тэгээд та бол нэлээн уг нь реформ хийхүйц ийм хүн гэж таныг олон нийт дүгнээд байна. Жишээлбэл 96-аас би өмнө нь ч хэлж байсан 2000 оны хооронд ажиллаж байсан тэр яамд гэхэд чинь жишээлбэл боловсрол, соёл, тэгээд тэр хүнтэй холбоотой яамыг чинь ерөөсөө Гэгээрлийн яам гээд нэгхэн яам. Тэгээд энд хүний үнэт зүйл, хүний хөгжилтэй холбоотой зүйлүүдийг нэг. Дэд бүтцийн хөгжлийн яам гэнгүүт нөгөө зам, тээвэр, барилга, хот байгуулалт, эрчим хүч гээд эд нарыг нэг яам болгочих ийм бүрэн боломж байсан юм. Тэгээд та харамсалтай нь энийг бол хийсэнгүй.

2 дугаарт энд нэг судалгаа байна л даа. 226 мянган төрийн албан хаагчдаас 32,8 хувь буюу 74 мянган хүн удирдах албан тушаал хашиж байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ бүтэц ингээд энэ янзаараа цаашаа хэдэн хувь нөгөө 9 хувь гэдгийнхээ дагуу зөвхөн 9 хувь нь өөрчлөгдөөд, тэгээд цаана нь дахиад нэлээдгүй хувь нь нэлээд олон хувь нь тэр чигтээ удирдлагын түвшинд ажиллах нь гэдэг ийм харамсал төрж байна. Тэгэхээр энэ удирдах албан тушаалтнуудынхаа тоог цөөлөхөөс энэ ажил чинь эхлэх юм биш үү? Яах вэ давхардсан бүтцийг янзална гэж байгааг нь ойлгож байна. Тэр бол мэдээж зөв.

3 дугаарт нөгөө мега төслүүд энэ хөгжлийн бодлого тэр чигтээ буюу ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр явна гэж хэлж байна. Тэгэхээр энэ дотор чинь нөгөө 14 мега төсөл хэмээх үлгэр маань тэр чигтээ үргэлжлэх юм уу? Энэ үлгэрээ одоо дуусгах юм биш үү? Энэ үлгэрээ дуусгаад, ерөөсөө хамгийн чухал тэр эрчим хүчний, тэр нефть боловсруулах газрын тосны үйлдвэр энэ хоёрыгоо түлхүү илүү ач холбогдол өгөөд, бусад тэр 10 орчмыг нь болиулдаг ч юм уу нэг ийм маш дорвитой өөрчлөлтүүд хийхгүй бол яг ингээд хуучин засаг, хуучин ажилтайгаа тэр чигтээ зууралдаад үлдэх ийм зураг харагдаад байгаа юм.

Бас нэг асуулт. Энэ нөгөө ажлын байр нээлттэй байгаад хүн ирдэггүй гэдэг нэг асуудал байнга яригддаг. Тэгэхээр та хэд орчим мянган ажлын байран дээр хүн очихгүй байгаа юм бэ, энэ талаар тоо баримт байна уу? Тэгэнгүүт нөгөө төрийн албан хаагчдын тоог цөөлнө гээд байгаа чинь нөгөө тэнд байгаа хүмүүс нь.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулъя, хэн хариулах вэ? Занданшатар Ерөнхий сайдын микрофон өгье.

Г.Занданшатар: Жудагийн Баярмаа гишүүний асуултад хариулъя. Баярмаа гишүүнтэй санал нэг байна. Энэ төрийн албаны шинэтгэл бол удирдах албан тушаалтнуудыг цомхотгохоос эхэлж байгаа гэж хэлж болно. Жишээлбэл Эдийн засгийн хөгжлийн яам гэхэд 28 газар, хэлтсийн даргатай болчихсон байсан. Энийг 50 хувиар цомхотгох үүрэг өгсөн. ЗГ-ын анхны хуралдаанаар бүх сайд нарт үүрэг даалгавар өгч энэ давхцал гаргадаг, ард иргэдийг чирэгдүүлдэг, давхацсан энэ орон тоонуудыг 2 дахин бууруулах чиглэл өгсөн. Энэ үндэсний хороод ч гэсэн тэр. Би ганцхан жишээ хэлье. Яагаад энэ яамдын тоог нэрийг өөрчлөөд ингээд бужигнуулахгүй байгаа юм бэ гэдэг дээр би ганц жишээ хэлье. Ингэнгүүт бүх бодлого бужигначихдаг юм байна лээ. Жишээлбэл Эрчим хүчний яам дээр 5 толгойтой болчихсон байсан, хариуцлага эзэнгүй, дэлбэрэлтийн шалтгаан олддоггүй, хариуцах субъектгүй. Ингээд хараад үзэхэд 97, 1987 онд анх 5 жилийн

төлөвлөгөөнд Багануурт цахилгаан станц байгуулна гэж төлөвлөж байсан юм байна лээ. Тэрнээс орж ирээд л нэг яам солигдох болгондоо Багануур дээр цахилгаан станц барих гэж байхад Тавантолгой дээр цахилгаан станц барина гээд л, сүүлд нь Хонхорт барина гээд Сономпил сайд, биш тэрний өмнө сайд дээр очсон. Хонхорт барьж байсан шалгаруулчихсан, концесс шалгаруулчихсан явж байсныг Багануурт барина гээд л ахиад концесс шалгаруулчихаад явж байсныг, ахиад л өөр газар барина гээд. Ингээд л нэг сайд гарах болгондоо Монгол Улсад 5, 6 газар сольж, цахилгаан станц баригдаагүй.

Энэний үр дүнд яаж байна жилд 200-аас 400 сая долларын цахилгааны төлбөр гадагшаа төлөгдөж байна. Энэ мөнгөөр цахилгаан станц барьчих байсан энэ 10, 20 жилийн хугацаанд. Ингээд л яам солигдох болгонд нэр ус нь солигддог, томордог, жижгэрдэг, нэг сайд ирээд л энэ боловсон хүчний бодлого нь ч тэр, яам томорч, жижгэрэхдээ асуудал биш, бодлого тогтвортой байхаасаа гадна, хариуцлагатай байх нь их чухал байгаа юм. Тийм учраас бидний хувьд энэ яам, газар, хэлтсийн тоог бууруулах үүргийг өгөөд, бүх яамд өөрсдөөсөө эхэлсэн. Уг нь шинэ сайдууд чинь эхний Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээ 6 дугаар сарын 20-ны өдөр эхний хуралдааны тэмдэглэлээрээ яамны зохион байгуулалтын бүтцийг орон тооны хязгаар 100 хүртэл бол 5, 150 хүртэл 7, 150-аас дээш 9 л газартай байна газар, хэлтэстэй байна. Маш том данхайчихсан 28 газар, хэлтэстэй яам болчихсон байсан гээд л та бүхэн бод л доо. Энэ бүхнийг энийг ингэж цэгцэлж байгаа юм, тийм. Ингээд энэ нэг жишээ нь.

Өөрөөр хэлбэл дарга нарын тоог цөөлснөөрөө ард иргэдэд дарамт шахалт, чирэгдэл учруулаад байдаг баахан гарын үсэг, баахан хувийн бизнесүүдэд учирдаг дарамт шахалтыг л цөөлөхийг зорьж байгаа юм. Түүнээс биш энгийн төрийн албан хаагчдаа аль болох тогтвортой ажиллуулж, цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг нь олгож, хариуцлагатай ажиллахад чиглэгдэнэ. Одоо томилогдоогүй орон тоонуудыг хадгална. Улсын Их Хурлаас 9 хувиар бууруул гэсэн ийм тогтоол, чиглэл батлагдчихсан. Тэрнийг нэг талаас хэрэгжүүлж байна. Энэ хүрээндээ тооцож үзвэл 10 яамтай байсантай дүйцэх тийм олон хүнийг, дарга нарын тоог цөөлж байна. Үндэсний хороод, зөвлөлүүд, 28 үндэсний хороо, зөвлөл маш олон давхардал хийдэлтэй байсныг ганцхан яруу тод жишээг нь би жишээлбэл Эрчим хүчний яам дээр хэлж байна шүү дээ. Эрчим хүчний үндэсний хороо, Эрчим хүчний яам, Зохицуулах хороо, агентлаг, Эрчист-Ойл компани энэ тэр гээд маш олон давхцал бий болчихсон байсан. Эднүүсийг л давхцалыг арилгаж, цэгцэлж байгаа юм гэдгийг онцолж хэлмээр байна.

Бусад, энэ бусад асуудлаар тантай 100 хувь санал байна. Мэдээж заавал реформ бол ингээд л ард хүмүүст таалагдах гэж яамдын тоог нааш, цааш болгосондоо биш, үйл ажиллагааныхдаа, арга хэлбэрийнхдээ, хамгийн гол нь ард түмэнд ойрхон, ард түмэнд ээлтэй, тэдэндээ үйлчилдэг, хүмүүсийн төлөө хүнтэй хамтарч, хүний оролцоог хангаж шийддэг тийм ардчилсан реформ хийхийг л бид зорьж энэ бүрэлдэхүүнийг нь өөрчилж байна. Түүнээс биш нийтээр нь хоморголон халаад л биш. Төрийн албаны аттестатчилал явуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүн илүү нэмэлт тайлбар хийе.

Н.Учрал: Их Хурлаас баталсан энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хуулиар өөрөө Эдийн засгийн хөгжлийн яамны зорилго бол энэ нэгдсэн бодлогуудаа хангах чиглэлтэй юм билээ. Тийм учраас гадаадын хөрөнгө

оруулалт ч тэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого ч тэр, зөвшөөрлийн сангийн бодлого ч тэр, худалдааны бодлого ч тэр өөрөө Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байдаг нэгдсэн бодлогууд нь. Энэ утгаараа газар, хэлтсийн тоо бол нөгөө хариуцаж байгаа чиг үүргээрээ их олон байдаг. Тийм учраас Эдийн засгийн хөгжлийн яам бол анх ингээд байгуулагдаж байсан. Тэгээд энэ удаа мэдээж Засгийн газар дээр ийм хэмнэлтийн бодлого явж байгаа учраас чиг үүргүүдийг нэгтгээд, чиг үүргийн шинжилгээ хийгээд, газар, хэлтсийн тоог бууруулах арга хэмжээнүүдийг авахаар ажиллаж байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яам дээр Гантөмөр сайдын үед нөгөө шинжлэх ухааны бодлого нэмэгдэж байсан. Энэ утгаараа Шинжлэх ухааны бодлогын газар нэмэгдсэн. Бусдаар өөрөө энэ өөрөө нэгдсэн бодлогууд учраас чиг үүргээрээ бол олон хариуцах ажлууд байдаг. Тэр утгаараа газар, хэлтсүүдийн тоо бусад яамтай.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуултаа тодруулъя.

Ж.Баярмаа: Яах вэ энэ нөгөө маш том нэг зорилго ард нь яваад байгаа л даа. Нөгөө манайх чинь нэг талдаа ажилгүйдэлтэй, нөгөө талдаа ажиллах хүчний дутагдалтай болчихсон ийм сонин орон байгаад байгаа юм байна лээ шүү дээ. Тэгсэн мөртөө нөгөө ажиллах хүчнийх нь хэдэн хувь нь энэ төрд байгаад байдаг. Тэгээд тэр төр дээр дорвитой цомхотгол 9 биш, бараг 20, 30 хүртэлх хувийн цомхотгол байдаг юм уу, давхардал арилгаж байж сая тэр хүмүүс чинь нөгөө бусад дутагдаад байгаа салбар луу очих, ингэж байж нөгөө хөдөлмөрийн зах зээл чинь баланстай болох гэдэг маш том ийм бас нэг реформын шинжтэй уг нь ажил хийгдэх ёстой байгаад байгаа. Тэгэхээр одоо бол ер нь чилийсэн 3 жил байна. Тэгэхээр та уг нь тогтвортой ажиллая гэсэн бол дорвитой шинэчлэлээр ажлаа эхэлсэн бол энэ олон нийтийн таашаалыг ч гэсэн хүртэхээс гадна, асуудал чинь, тулгамдаад байгаа энэ бүх асуудал чинь нэг зөв голдирол руугаа уг нь ороод, тэгээд цаашаа зөв платформ дээр юмнууд чинь явах байсан юм л гэж би хараад байгаа юм л даа. Түүнээс магадгүй энэ чинь яг ингээд олон нийт бол ер нь юу өөрчлөгдсөн юм бэ гээд байгаа байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Шадар сайд Учрал хариулъя.

Н.Учрал: Шинжлэх ухаан дээр суурилсан хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, мониторинг гэсэн энэ цикл дээр л эргэх ёстой. Ер нь энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хууль ч гэсэн ийм л зорилготой. Тийм учраас Эдийн засгийн хөгжлийн яам нөгөө ирэх оны төсвийн төсөөллийг ч гэсэн үүн дээр суурилж боловсруулдаг. Төсвийн хүрээгээ ч гэсэн боловсруулдаг. Тэр мега төслүүд дээр гэхэд Эдийн засгийн хөгжлийн яамнаас бид мега төслүүдийг макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, төслийн бэлэн байдлын үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэр гээд 4 чиглэлээр үнэлээд, одоо 14 мега төслийг бид та бүхэнд танилцуулна. Жишээ нь 4 төсөл одоо эхэлчихсэн байгаа, санхүүжилт тодорхойгүй 5 төсөл байгаа. Тэгээд дээрээс нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох зарим төслүүд гээд ингээд бид яг энэ 4 чиглэлийн үнэлгээгээр үнэлээд, заримыг нь хойшлуулах арга хэмжээнүүдийг аваад, эхэлчихсэн ажлуудаа үргэлжлүүлэх гэсэн ийм төлөвлөлтөө бол та бүхэнд танилцуулна гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Манай сайдууд нэг өнөөдөр өглөө хөл дээрээ боссон юм шиг л өчигдөр юу байснаа мартацгаачихсан. Өнөөдөр хорвоо ертөнц гэнэт эргээд өөр болчихсон юм шиг л юм ярьцгаах юм. Та нар бүгдээрээ л энэ Засгийн газарт өмнөх Засгийн газарт байсан шүү дээ. Нөгөө онц сурдаг хүүхдүүд шиг хаанаас нь А, Б-гүй хариулцгаагаад л. Энэ Засгийн газрын хяналтын тухай хуулийг чинь жишээ нь хэн хэрэгжүүлэх юм бэ? Энэ, энэ хуулийн дагуу Дархан-Уул аймгийн Засаг дарга сүүлийн 3 жил тендергүйгээр худалдан авалт 65 тэрбумын зөрчил илрүүлсэн шүү дээ. Тэгээд тэрийг хэн хэрэгжүүлэх юм эхнийх нь?

Хоёрдугаарх нь тэр хүнд зориулж бүтэц хийдгээ болимоор байгаа юм. Би энийг 4 дэхээ хэлье. Эрчим хүчний хороо, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах газар гээд байхад нь Доржханд гэдэг хүнд зориулаад Эрчим хүчний реформын үндэсний хороо гэж хийгээд, тэр хүн нь энэ Жавхлан сайд руу 14,5 тэрбум төгрөг хүссэн бичиг байгаа шүү дээ. Та нар 8,4 тэрбум суулгаж өгсөн. Тэр мөнгийг чинь одоо үрээд дуусчихсан. Тэгээд энэ мэт ингээд бүтэц өөрчлөхөөр энэ татвар төлөгчийн 8,4 тэрбум төгрөг чинь ингээд та нарт хайран биш юм уу? Ингээд зүгээр тоглоод байдаг юм уу? Бүтэц өөрчлөөд л 8 тэрбум төгрөг үрээд л. Тэр бичиг дээр нь 10 тэрбумыг хэвлэл мэдээллийн зардал гэж бүр биччихсэн байгаа шүү дээ. 1,3 тэрбумыг гадаад томилолт. Ийм дураараа байж болдог юм уу?

Тэгээд одоо энэ улсын төсөвт тодотгол хийнэ гээд байгаа энэ тодотгол чинь ингээд л энэ мэт ингээд гарын салаагаар урсаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр ямар нэгэн хариуцлага байхгүй юм уу, Одоо яах юм бэ? Тэгээд энэ хороог нь татан буулгаад яах юм бэ? Тэр мөнгийг нь хэнээр төлүүлэх юм бэ? Тэгээд манай сайдууд гадаадад очиж санамж гэрээ зурсныгаа нэг их ажил хийсэн гэж битгий худлаа сурталчлаад бай. Санамж гэрээ бол санамж гэрээ, хамтран ажиллах гэрээ биш, хөрөнгө оруулалтын гэрээ биш. Одоо тэгвэл тэр 2 тэрбум долларыг нь оруулаад ир л дээ, тэгээд энэ эдийн засаг чинь хямралгүй болчихно шүү дээ. Ингэж ингээд худлаа ярьдгаа 1 дүгээрт болимоор байна. Тийм давхардуулдаг хүнд зориулсан бүтэц хийхээ болимоор байгаа юм. Тодорхойгүй болчихсон, ойлголтгүй болчихсон, хаана, юу хариуцаж байгаа мэдэгдэхээ больчихсон бүүр ийм.

2 дугаарт Наранбаяр сайд бас хажууд сууж байна. Би өнөөдөр өглөө 2 багштай уулзлаа, эрдмийн ерөнхий шалгалт өгсөн сурагчидтай уулзлаа. Тэр нийгмийн хичээлийн шалгалт дээр манайд Монгол Улсад ямар Солонгос жүжигчин ирсэн бэ гэж асуудаг нь боловсролын ямар яг ойлголт юм бэ? Энэ чинь хөл, толгой нь олдохоо болилоо шүү дээ. Хэнээс, юу асууж байгаа нь хүртэл ойлгомжгүй болчихсон.

Төрийн байгуулалтын байнгын хороо одоо нэг ирц нь хүрээд, хуралдаад байх шиг байна. Хамгийн их хойшилсон, дандаа сайдууд байдаг, хуралдаа ирдэггүй, ирцдээ орчхоод гарчихдаг. Тэгээд энэ давхардсан чиг үүргүүдээ яах юм бэ, энд гарсан зардлуудаа яах юм бэ, зүгээр ингээд өнгөрөөгөөд үлдэх юм уу? За, за энэ бүтцийг нь татан буулгачихлаа, шаардлагагүй байсан юм байна гээд. Тэрбум, тэрбум төгрөг чинь их мөнгө биш юм уу? Тийм баян улс болчихсон юм уу бид? Гарын салаагаар мөнгө.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Занданшатар Ерөнхий сайд хариулах уу?

Г.Занданшатар: Энэ хуулиар тэр хороодыг чинь татан буулгаж, энэ зардал чинь хэмнэгдэж байна. Миний ойлгож байгаагаар та бүхэн тэр өмнөх хуулийг Засгийн газрын бүрэлдэхүүний хуулийг баталж, хэрэгжүүлсэн. Тэр үедээ ярих, асуух ёстой асуулт байсан байна гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Шижир гишүүний асуултад хариулъя. Сая яг энэ хэсэг нь нэлээн таслагдаад нийгмийн сүлжээгээр зөндөө явчихсан. Яг энэ асуулт. Би өөрөө өөрийн бүүр биеэр энэ ямар сонин юм гээд гарлаа. Нийгмийн ухааныхаа шалгалтад байна, тэгээд их байна, нэг тийм уншихад нөгөөд нэлээн төвөгтэй ийм эх байна. Солонгосын жүжигчид Монголд ирээд ийм, ийм ажлыг хариуцаж явсан ийм байна гээд нэг тийм текст. Тэгээд тэрнээсээ задалж асуусан байна. Энэ үгнийх нь үүрэг нь юу байсан юм, яасан гээд энэ зөвийг нь холбож хариулна уу гэсэн ийм байсан. Тэгэхээр шалгалтын техникүүд бий сонирхолтой янз янзын текстүүд авчраад уншуулаад, тэндээсээ логикийн зөв гаргалгаа гаргаж байна уу гэдгийг л харах зорилготой ийм асуулт байсан. Тэгээд тэр хэсгийг нь зүгээр тэр нэрийг нь тавиад 1 жүжигчний тухай асуулаа гээд. Тэр жүжигчний тухай асуусан юм юу ч байхгүй, тэр зөвхөн эхтэй холбоотой л асуултууд байгаа. Ер нь иймэрхүү шалгалтын техникүүд байдаг. Та бүхэнд ч гэсэн янз янзын шалгалт өгч байсан байх. Хэлний.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Тийм тэр анх ЗГ-ын бүтэц өгөхөд би эсрэг санал өгсөн юм. Яагаад гэхээр маш олон давхардсан чиг үүргүүд байгаад байна, үүн дээр чинь маш их зардлууд байна гээд. Жишээ нь тэр Эрчим хүчний үндэсний реформын хороо гээд гоё нэртэй, төрийн албан хаагчаас өндөр цалинтай, ТНБД-аас 4 дахин, бараг 3 дахин өндөр цалинтай ийм хүмүүс байна. Өнгөрсөн хугацаанд юу хийсэн бэ гэхээр цахилгаан дулааны үнэ нэмээд, 650 тэрбум төгрөг цугласан. Зөвхөн цахилгааны үнэ нэмээд. Энэ бол иргэд болон ААН-ээс авч байгаа мөнгө шүү дээ. Тэгээд эргээд юу ч хийгээгүй, нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээгүй. Тэгээд ийм байдлаар тухайн хүнд зориулсан бүтэц гаргасан зардлыг хэн хариуцах юм бэ? Би энийг л асуугаад байгаа шүү дээ. Хэн хариуцах юм бэ? Тухайн 8 тэрбум төгрөг зарцуулаад дуусаж байна энд хэн хариуцлага хүлээх юм бэ гэдэг л би асуулт асуугаад байгаа юм. Энэ Жавхлан сайд руу яг бичсэн албан бичиг нь байгаа шүү дээ. Мэдээлэл сурталчилгааны зардал дээр 10 тэрбум, гадаад томилолт дээр 1,3 тэрбум.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайд Жавхлан хариулъя, 5 номерын микрофон. 5 номерын микрофон.

Б.Жавхлан: Шижир гишүүний асуултад нэмээд мэдээлэл өгье. Доржханд Шадар сайдын хувьд эрчим хүчний ер нь реформ гэдэг энэ агуулгаа үргэлжлүүлнэ, үргэлжлүүлнэ. Тэр төсвийн хувьд тодорхой хэмжээний таналт, хэмнэлтэд орж таараа. Эцэслэж тоо нь хараахан гараагүй байгаа. Энэ хэлэлцүүлгийн шатад явж байгаа гэж та бүхэн мэдэж байгаа. Тийм учраас тэнд хариуцлага тооцно гэдэг юм уу, цоо шинэ ажил нь өөр тийшээ шилжээд, ажил нь хийгдээгүй эд нар гээд тийм асуудал огт байхгүй. Энэ чинь нэлээн том хэмжээний реформ хийж байгаа шүү дээ. Дөнгөж эхэлж байна, энэ реформ нь цаашаагаа үргэлжилнэ. Доржханд сайд өөрөө энийгээ хариуцаад үргэлжилнэ. Хугацааны эцэст харин ямар үр дүнд хүрвэ,

зорьж байсан зорилтдоо хүрэв үү, үр дүн нь юу болов гэдэг хугацаа бол болоогүй байгаа гэж ингэж харж байгаа. Тийм учраас тодорхой хэмжээний төсөв нь хэмнэгдэнэ, яг гол үүрэг хариуцлага нь үргэлжилнэ. Үндэсний хорооны хэмжээнд бол байхгүй, тэр бүтэц татан буугдаж байгаа. Орон тоонууд нь багасаад.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар нэмж хариулъя.

Г.Занданшатар: Тэгээд ер нь Шижир гишүүн зөв зүйтэй зүйл ярьж байна л даа. Тэрнийг онцлон тэмдэглэх ёстой. Энэ үр ашиггүй зардал, энэ үндэсний хороод дээр, энэ сангууд дээр ийм үргүй зардал асар их байсан нь үнэн юм билээ. Ийм учраас энэ 28 хороод сангуудыг татан буулгаж, Кино урлагийг дэмжих сан, Өргөн нэвтрүүлгийн сан л гэнэ, нөгөө түрүүчийн сангуудын дуулиан тасраагүй байхад дахиад энэ сангууд, тэгээд энэ үндэсний хороод дээр асар их зардлууд хуваарилагдсан байсныг л энэ бүрэлдэхүүний тухай хуулиар бүгдийг нь татан буулгаж, чиг үүргүүдийг нь холбогдох сайдууд дээр төвлөрүүлж, зардлыг нь зайлшгүй зардлуудыг нь танаж ингэж төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлэх ийм бодлого явуулж байгаа. Тийм учраас таны тэр шүүмжилж байсан бодлого энд хэрэгжсэн байна гэж та ойлгож болно.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Баярбаатар гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн.

Б.Батбаатар: Байнгын хорооныхоо гишүүдэд өдрийн мэнд хүргэе. ЗГ-аас оруулж ирсэн бүтэц, бүрэлдэхүүний хуулийг дэмжиж байгаа. Тодорхой түвшинд бүтцээ бууруулж байна, энийгээ дагаад урсгал зардал нь хэмнэгдэж байна, дагаад олон хороод татан буугдах. Мэдээж өмнө ч тэр, одоо ч тэр, ирээдүйд ч тэр төгс зүйл гэж угаасаа хаана ч байхгүй. Тэгэхээр бид энэ байгаа зүйлээ нэлээдгүй анхаараад ажиллалчих болов уу.

Би нэг зүйл дээр эсрэг байр суурьтай байгаа юм. Энэ хэвлэлээр сүүлийн үед нэлээн яадаггүй олон хүний анхаарлыг татаад, зарим нэг зүйл дээр буруу зөрүү мэдээллүүд яваад байгаа юм. Энэ төрийн албан хаагчдыг 26 оны хөгжлийн хөтөлбөр дээр 9 хувиар бууруулна гээд ороод ирчихсэн. Тэр үе дээр би яг хэлж байсан юм. Энийг яаж бууруулах юм бэ, ямар аргачлалаар бууруулах юм бэ, зүгээр нэг ингээд байгууллагуудад битгий квот өгчхөөрэй, арай нэг өөр аргачлал юмнууд байвал танилцуулаад ингээд яваарай гэсэн. Тэгээд өнөөдөр яг байгууллагуудаас асуусан чинь квот өгчхөж. Би хэд хэдэн байгууллагын дарга нартай асуулаа. Манайхаас 18 хүн, манайхаас тэдэн хүн гээд. Одоо тэгээд ямар хүнийг халах вэ гээд, тэгээд 14 мянган хүний асуудал байгаа юм шиг байгаа юм. Тэгээд энэ дээрээ нэг эргэж харахгүй бол Засгийн газар. Энэ чинь тэгээд нэг хөгжлийн хөтөлбөр гээд байдаг, тэгээд 14 хүнийг нэг амьдралаас нь салгачхаад хөгжлийн хөтөлбөр гэж ярих нь өөрөө зөв үү, буруу юу?

Тэгээд баахан тэр нөгөө хууль дээр байхгүй тэр нэг түр орлон гүйцэтгэгч билүү тэр дарга нараа яагаад чөлөөлөхгүй байгаа юм бэ? Тэр 400 нөгөө бүтээмж дээшлүүлэх билүү нэг менежерүүд байгаа шүү дээ. Тэдний чинь цалингийн зардал гэхэд бараг 30 тэрбум юм байна шүү дээ. Энэ хэмнэх боломжтой зүйлүүдээ чөлөөлөөд явах нь зөв байх. Мэдээж төрийн албыг данхайсан, нэг чиг үүрэг дээр олон хүн давхцаж байгаа энэ тэр гэдэгтэй байр суурь нэг байгаа. Тэгэхдээ зүгээр

нэг ийм сугалааны маркаар ч юм уу эсхүл нэг эрх мэдэлтэнд нь, удирдлагад нь шууд нэг ийм үүрэг өгөх байдлаар хүнийг амьдралаас нь салгаж болохгүй байх гэсэн байр суурьтай байна. Сангийн сайд хэвлэлийнхэнд хэлсэн байна лээ. 9 хувь бууруулж, 10 хэдэн, 14 мянган хүнийг ажлаас нь чөлөөлнө гээд. Тэгээд энэ бүгд чинь тэр яг иргэд дээрээ очихоор, яг төрийн албанд ажиллаж байгаа тэр улсууд дээрээ очихоор ямар хүнд тусдаг гэж бодож байна. Бид өөрсөд дээрээ тийм үг хүлээж авч байна гээд бодоод үз л дээ. Тэгэхээр эдгээр зүйлүүдээ анхаарахгүй бол энэ нийтлэг эрх ашиг дээрээ хэдүүлээ жоохон хатуу зогссон нь дээр байх. Мэдээж реформ хийлгүй л яах вэ, шинэчлэл байлгүй л яах вэ, шилжилт байлгүй л яах вэ. Тодорхой шийдвэрүүдийг гаргалгүй л яах вэ.

Тийм учраас энэ төрийн албан хаагчийг энэ бууруулах энэ тоон дээр жоохон эсрэг байр суурьтай байгаагаа илэрхийлье. Тэгээд одоо Байнгын хороо дэмжээд өнөөдөр энэ Засгийн газрынхаа бүтэц, бүрэлдэхүүний хуулийг яаралтай батлаад, дараа дараагийнхаа асуудал руу орсон нь зөв болов уу гэж бодож байна. Тэгээд энэ бусад гишүүдийн хэлсэн саналууд, асуултуудыг бодож үзээд явах нь зөв байх. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Занданшатар.

Г.Занданшатар: Баярбаатар гишүүний хэлж байгаа зөв, санал нэг байна. Энгийн ажилтнуудыг хоморголон халаад, улс төржүүлээд аливаа байдлаар тэгш шударга зарчим үүсгэж болохгүй. Тоо квот өгөөд байгаа юм байхгүй. Тэр 400 менежер чинь худлаа тоо шүү гэдгийг харин тодруулах гэсэн юм. 42 бүтээмжийн 42 менежер ажиллаж байгаа. Тэгэхдээ тэдний ихэнх нь нөгөө яг төсөвт байгууллагууд биш, төрийн өмчийн компаниуд дээр ажиллаж байгаа учраас төрийн өмчийн компаниудын реформ дээр тэр бүтээмжийн менежерүүдтэй холбоотой асуудлууд шийдэгдэнэ. Тэр орон тоо өгч байгаа юмнууд бол ажилд аваагүй хоосон орон тоо 6900 билүү, 400 билүү Жавхлан сайдаа, Жавхлан сайдыг гүйцээгээд хариулчих. Тэр, тийм 6 мянга орчим ажилд аваагүй орон тоо, тэтгэвэрт гарах энэ тэр гээд ингээд юм байгаа, тэрнийг эхний ээлжид цомхотгоно. Хүн аваагүй байгаа орон тоо учраас хүн халахгүй гэсэн үг. Дараа нь дээр нь 260 дарга цөөлнө гэх мэтчилэн ийм тодорхой тоотой реформууд энд хийгдэх юм байгаа юм. Энийг залруулчих нь зүйтэй байх. Тэгэхгүй бол 400 бүтээмжийн менежерүүд.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүнээс 12 гишүүн оролцож, 75 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүнээс 12 гишүүн оролцож, 75 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68,8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн, хуулийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүнээс 13 гишүүн оролцож, 81,3 хувиар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 16 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 81,3 хувиар санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүнээс 13 гишүүн оролцож, 81,3 хувиар санал дэмжигдлээ. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлын хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна.

15.44 цаг

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА